

“Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн 2021 оны 04 сарын 28-ны өдрийн

Ээлжит хурлын тэмдэглэл:

2021 оны 04 сарын 28 өдөр

№01

Улаанбаатар хот

Хаана: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж, Модерн Таун хотхон,
“Бэрх Уул” ХК-ийн оффисын байр

Эхэлсэн цаг: 09:00 цагт

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Даваажав, хурал зохион байгуулах комиссын гишүүн Ч.Сарнай, хурлын нарийн бичиг Н.Содончимэг, тооллогын комиссын дарга Л.Тэмүүжин, тооллогын комиссын гишүүн Ө.Наранчулуун, Д.Уянга нар, итгэмжлэлээр 4 хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцов.

Тооллогын комиссын гишүүн Д.Уянга “Бэрх Уул” ХК-ийн 2021 оны 04 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцууллаа. Нийт 19’062’080 ширхэг хувьцаанаас нийтдээ 99.66% буюу 18’997’615.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өөрийн биеэр оролцож хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдэж байна.

Хурлын ирц: 99.66 хувь

Хурлын дарга А.Даваажав: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
- Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
- Хурлын завсарлага
- Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- Хурлыг хаах

Хурлын дарга компанийн гүйцэтгэх захирал А.Даваажав хуралд оролцогч талуудтай мэндчилж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2021 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хэлэлцэн батлах
3. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох
5. Компанийн хэлбэрийг өөрчлөх талаар ажлын хэсгээс бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлах
6. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах.
7. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
8. Хөрөнгө шилжүүлэх, худалдах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
9. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах

Хурлын дарга А.Даваажав: 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. **Хурлын дарга А.Даваажав** Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцүүлэв.

“Бэрх Уул” ХК нь 2020 онд Дэлгэрхааны жоншны хэсгийн үйл ажиллагааг эхлүүлэх, бичиг цаасны ажлыг дуусгах, хөрөнгө оруулалт татах мөн Чандганы орд газраас нүүрс олборлон борлуулах, гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан.

Компани нь 2020 онд жоншны хэсгээс орлого олоогүй бөгөөд зөвхөн нүүрсний хэсгээс 1370,07 сая төгрөгийн орлоготой, ерөнхий удирдлагын зардалд 631,5 , ханшийн зөрүүний алдагдалд (1238,71), мөн шүүхийн шийдвэрийн дагуу торгууль алдангийн зардалд (845,38) мөн зээлийн хүүгийн зардалд 1907.19 сая төгрөг гэх мэт зардлуудтай ажилласнаар (3830.93) сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Мөн Эм Эн Юу Би Кредит ХХК-тай холбоотой өрийн асуудлыг

Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн шатанд холбогдох өр төлбөрийг барагдуулсанаар бүрэн шийдвэрлэсэн.

Компанийн 2020 оны жилийн орлогын тайлан нь дараах байдалтай байна.

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2019 он	2020 он
Борлуулалт	сая. төг	1,355.18	1,370.07
ББӨ	сая. төг	889.51	600.95
Нийт ашиг (алдагдал)	сая. төг	465.67	769.11
Бусад орлого	сая. төг	292.87	48.69
Ерөнхий удирдлагын зардал	сая. төг	576.02	631.50
Санхүүгийн зардал	сая. төг	1,948.46	1,907.19
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	(1,765.94)	(1,720.88)
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая. төг	(28.95)	(25.96)
Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	сая. төг	(968.40)	(1,238.71)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая. төг	(2,763.29)	(2,985.55)
Орлогын татварын зардал	сая. төг	0.06	
Алданги торгууль	сая. төг		(845.38)
Татварын дараах ашиг (алдагдал)	сая. төг	-2,763.35	-3,830.93

Санхүү байдлын тайлан 2020

№	Хураангуй баланс	2019 он	2020 он
1	ХӨРӨНГӨ:		
2	Эргэлтийн хөрөнгө	254.25	160.30
3	Эргэлтийн бус хөрөнгө	13,981.04	14,515.53
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,235.29	14,675.82

5	ӨР ТӨЛБӨР:		
6	Богино хугацаат өр төлбөр	16,839.12	19,441.67
7	Урт хугацаат өр төлбөр	30,348.79	32,017.70
8	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:	47,187.91	51,459.37
9	ЭЗДИЙН ӨМЧ		
10	Хувийн өмч	1,906.21	1,906.21
11	Дахин үнэлгээний нэмэгдэл	1990.69	1,990.69
12	Хуримтлагдсан ашиг	-36,849.51	-40,680.44
13	ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН	-32,952.61	-36,783.54
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	14,235.29	14,675.82

Компани нь санхүүгийн тайлан баланс, болон аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны албан татвар, агаарын бохирдлын албан татвар мөн нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь тогтмол гаргаж тайлагнадаг.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэл: 2020 онд /төгрөгөөр/

№	Татварын төрөл	2020 оны 01.01 үлд	Үүссэн	Төлсөн	2020 оны 12.31 үлд
1	Агаарын бохирдол	(21,630)	31,097,380	27,835,625	3,240,125
2	АМНАТ	(25,454)	37,353,058	13,716,022	23,611,582
3	ААНОАТ	-			-

4	НӨАТ	81,605,139	110,903,382	44,522,839	147,985,682
5	ХАОАТ	-	19,090,306	9,785,168	9,305,138
6	Суутган 10				
7	АТӨЯХАТ	-			-
8	АТӨЯХАБТ	-			-
9	ҮХХАТ	-	6,472,361	6,472,361	-
10	Галт зэвсэг	-			-
11	Газрын төлбөр / Бэрх /	-	212,778	212,778	-
12	Газрын төлбөр / Дэлгэрхаан /		478,839	478,839	-
13	Газрын төлбөр / Чандган /		2,097,600	2,097,600	-
14	Хог хаягдал / Чандган /		669,000	669,000	-
15	Татвар акт				-
16	НД-н шимтгэл	(500,727)	66,103,483	16,624,894	48,977,862
Бүлгийн дүн		81,057,327	274,478,187	122,415,125	233,120,389

2020 онд компани нь татвар нийгмийн даатгалын шимтэлийн өглөг 274,5 сая төгрөг үүссэнээс 122,4 сая төгрөг улс орон нутгийн татварт төлсөн байна.

Чандганы хэсэг

ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Чандган талын хүрэн нүүрсний орд нь Нялгын нүүрсний сав газрын зүүн хойд хэсэгт Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Шорвогийн тал хэмээх газарт оршдог. Улаанбаатар хотоос 290км-т зүүн чиглэлийн мянганы замаас урагш 5км Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотоос баруун хойш 54 км зайд байрладаг.

Тус орд нь дэд бүтцийн хувьд зам харилцаа, цахилгаан холбоо хөгжсөн, хүн ам суурьшсан төв суурин газруудтай ойрхон, эдийн засгийн харьцангуй тааламжтай нөхцөлд оршдог. Газрын гадаргуугын усан сүлжээний хувьд байнгын урсгал ус байхгүй, тогтмол нуур, цөөрөмтэй. Энд тогтсон нуурууд нь хур тунадасны усаар тэжээгддэг давстай нуурууд байдаг. Орд нь зүүн хойноос баруун урагш сунасан 1400-1500м өндөртэй уул

нуруугаар хязгаарлагдсан уулс хоорондын далайн түвшнээс 1150-1188м-т өргөгдсөн хөндийд байрлана. Газрын гадаргын хувьд жижиг дов, толгод зонхилсон хотгор, гүдгэртэй тал хээрийн бүсийн шинжтэй гадаргуутай. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, зун нь харьцангуй дулаахан, 15-35 хэм хүртэл халах ба бороо хурын үед сэрүүвтэр байна. Өвөл нь 25-37 хэм хүйтэн, эхний цас 10-р сарын эхээр орно. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 350мм бөгөөд үүний ихэнх нь 6-8 дугаар сарын хооронд ордог. Салхины чиглэл голлон зүүн хойноос баруун ургаш чиглэлтэй 20 м.с хүртэл хурдтай байна. Орон нутгийн хүн ам ихэнхи нь мал аж ахуй болон газар тариалан эрхлэн үр тариа, хүнсний ногоо тарьж орон нутгийн хэрэгцээг хангана.

Чандганы нүүрсний уурхайг ЗГ-ийн 1999 оны 05-р сарын 02-ны өдрийн 74 тоот тогттолын дагуу “Бэрх Уул” ХК-ийн бүрэлдэхүүнд нэгтгэсэнээс хойш өнөөдрийг хүртэл хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг явуулж Хэнтий аймгийн төв болон зарим сумдыг нүүрсээр ханган тасралтгүй ажиллаж ирсэн.

Тус уурхайн олборлолтын хэмжээ нь Хэнтий аймаг болон бусад сумдын хэрэглэгчийн жилийн хэрэгцээнээс шууд хамааралтай.

Чандганы хэсгийн 2020 оны борлуулалт үйл ажиллагаа

Чандганы нүүрсний уурхай нь орон нутгийн чанартай нүүрсний уурхай тул дотоодод буюу Хэнтий аймгийн төвийн болон бусад сумдын аж ахуй нэгж, хувь хүмүүст жилийн 1-4, 10-12-р саруудад нүүрс олборлон борлуулдаг.

Нүүрсний үнийг эрчим хүчний зохицуулах хорооноос гаргаж тогтоодог. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 03-р сарын 29-ны өдрийн 126 дугаар тогтоолоор нэг тонн нүүрсийг 2018.04.01-ний өдрөөс эхлэн төвлөрсөн халаалтын зуухнуудад болон үйлдвэр аж ахуйн газарт (НӨАТ-гүй үнэ) 23000 төгрөгөөр борлуулж байгаа.

2020 онд төвлөрсөн халаалтын зуухнууд болон үйлдвэр аж ахуйн газарт 56805.80 тн нүүрсийг олборлон борлуулж, нийт 1370.07 сая төгрөгийн орлого олсон.

№	Төрөл	Хэмжих нэгж	2018	2019	2020
1	Нүүрсний борлуулалт тн	тн	51,740.50	58,157.09	56,805.80
2	Нүүрсний борлуулалт	сая.төг	1,149.02	1,355.18	1,370.07

	/төг/				
3	ББӨ	сая.төг	932	889,51	816.34
4	Нийт ашиг	сая.төг	217.02	465.67	553.73

Тус хэсгийн жилийн зардлыг үндсэндээ хугацаагаар нь 3 хуваасан бөгөөд жилийн эхэн үе /1-5/ сар, дунд үе буюу хөрс хуулалтын үе /6-9/ сар, сүүл буюу /10-12/ сар гэж хувааж тайлагналаа.

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нүүрс борлуулалтын үе	Хөрс хуулалтын үе	Нүүрс борлуулалтын үе	Нийт дүн
1	Цалингийн зардал	мян.төг	84,075	113,390	54,295	251,760
2	НДШ	мян.төг	11,889	16,059	7,706	35,655
3	Сэлбэг хэрэгслийн зардал	мян.төг	23,607	22,642	28,936	75,184
4	Тээврийн зардал	мян.төг	1,636	-	2,378	4,015
5	Түрээсийн зардал	мян.төг	-	28,680	-	28,680
6	Амнат	мян.төг	15,973	-	18,279	34,252
7	Агаарын бохирдол	мян.төг	13,635	-	14,768	28,403
8	Хангамжийн материал	мян.төг	1,240	1,366	450	3,056
9	Хөдөлмөр хамгаалал	мян.төг	1,026	3,227	360	4,613
10	Хүнсний зардал	мян.төг	8,352	15,496	12,639	36,487
11	Элэгдэл	мян.төг	-	10,871	15,219	26,091
12	Томилолтын зардал	мян.төг	-	-	-	-
13	Шуудан холбоо	мян.төг	35	202	25	262
14	Шатахууны зардал	мян.төг	52,992	79,668	31,068	163,728
15	Тос тосолгооны материалын зардал	мян.төг	2,788	18,208	1,085	22,081
16	Зээлийн хүүгийн зардал	мян.төг	-	62,654	-	62,654
17	Байгаль	мян.төг	3,900	-	3,350	7,250
18	Шинжилгээ, тайлан	мян.төг	399	-	6,309	6,708
19	Бусад зардал	мян.төг	3,336	-	2,794	6,130
20	Ашиглалтын зардал	мян.төг	6,742	4,284	1,425	12,452
21	ТУЗ	мян.төг	-	-	-	-

22	Урсгал засвар	мян.төг	3,358	-	885	4,243
23	Бичиг хэрэг	мян.төг	134	191	188	513
24	Банкны шимтгэл	мян.төг	2	17	14	32
25	Газрын төлбөр	мян.төг	-	-	2,100	2,100
Нийт дүн		мян.төг	235,119	376,956	204,273	816,348
Үе тус бүрийн зардлын хувь			28.80%	46.18%	25.02%	100%

Эхэн үе буюу /1-5/ сар

Энэ үед өмнөх жилийн хөрс хуулж бэлдсэн нүүрсээ борлуулдаг бөгөөд гол борлуулалт 1-р сард байдаг үүнийгээ дагаад ачаалал ихэсдэг мөн байгаль цаг уурын байдал зэргээс шалтгаалж техникийн эвдрэл гэмтэл их гарч сэлбэг, шатах тосох материалын зардал ихэсдэг. Мөн тус уурхайн уулын нөхцөлөөс хамаарч 1-р сарын сүүл 2-р сарын эхэн үеэр уурхайн уулын нөхцөл хүндэрч устай шаварлаг болж ирдэг. Үүнийгээ дагаад хөрс цэвэрлэгээ, бага зэргийн хөрс хуулалт зэргийг дахин хийдэг. Энэ үе нь Чандганы уурхайн нийт зардлын 28-32 хувь хүртэл байдаг.

Дунд үе буюу хөрс хуулалтын үе /6-9/сар

Үндсэндээ компани нь хөрс хуулалтын бэлтгэл ажил, техникийн засвар үйлчилгээг 6-р сараас эхлэн бэлддэг. Хөрс хуулалтын гол хугацаа нь 7-р сарын 25-с 10-р сарын 1-хүртэл байдаг. Гэвч байгаль цаг уурын байдал, техникийн эвдрэл гэмтэл, мөн зарим хүчин зүйлээс шалтгаалж хөрс хуулалты ажил сунжирах үе байдаг.

Мэдээж хөрс хуулалтын үе нь тус хэсгийн болон компанийн хамгийн чухал үе байдаг. Хөрс хэр амжилттай хуулна, мөн нүүрс хэр сайн гарна үүнээс шалтгаалан цаашдын үйл ажиллагаа, ашиг алдагдалд маш чухал байдаг. Уг үеийн зардал нь нийт зардлын 46-с бараг 50 шахуу хувь байдаг.

Сүүл үе буюу хөрс хуулалтын дараах үе /10-12/сар

Тухайн жилийн хөрс хуулалтын ажил дуусч шинэ халаалтын циклийн үе эхэлдэг. Энэ нь тус оны 10-12 сар дараа оны 1-4 сарууд байдаг.

Жил бүрийн 10-р сарын 1-н гэхэд харилцагч байгууллагуудтай нүүрс худалдах, худалдан авах гэрээг хийдэг.

Хөрс хуулалт

“Бэрх Уул” ХК-ийн Чандганы нүүрсний уурхайн хэсэг нь хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалан техник шинэчлэлт хийж чадаагүй, мөн уул геологийн нөхцөл хүндэрсэн зэргээс шалтгаалан сүүлийн 5 жилийн хугацаанд иргэн, аж ахуй нэгжээс техник тоног төхөөрөмж түрээслэж хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байсан.

Компани нь хөрс хуулалт болон цаашдын үйл ажиллагаанд зориулж автосамосвал 2 ширхэгийг 91.5 сая төгрөгөөр 2020 оны 5-р сард худалдан авсан.

2020 оны 6-р сарын 1-нээс хөрс хуулалтын ажлыг эхэлсэн боловч байгаль цаг уур, хөрөнгө санхүү, мөн техникийн дутмаг байдал /Экскеватор/ эвдрэл, гэмтэл зэргээс шалтгаалан төдийлэн сайн гүйцэтгэж чадалгүй 2020 оны 7-р сарын 3-с наадмын амралтыг эхлүүлсэн.

2020 оны 7-р сарын 27-нд Doosan-500 экскеватор-г иргэн Амгалантөрөөс “Тоног төхөөрөмж худалдан авах гэрээ” №ХХАГ-01/2008 тоот гэрээний дагуу 250,0 сая төгрөг, төлбөрийг 3 хувааж төлөх, гэрээний үлдэгдэл төлбөрт сарын 2% хүүтэйгээр зээлээр худалдан авсан.

Өмнөх жилүүдийн хөрс хуулалтын ажилд экскеватор, автосамосвалл зэрэг техникийг иргэн аж ахуйн нэгжээс түрээслэдэг байсан бол энэ жил эксковатор түрээслэлгүй зөвхөн автосамосвалл 4-г түрээслэж хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээр түрээсийн зардлыг бууруулж өгсөн. 2020 оны жилийн нийт хөрс хуулалтын зардал 376,9 сая төгрөг болсон бөгөөд *215,4 сая төрөгийг 2021 оны 1-4-р саруудад тэнцүү хэмжээгээр зардалд хувиарлахаар балансын бусад эргэлтийн бус хөрөнгөд капитаалжуулсан.*

Ингээд тус уурхайн хамт олон 2020 оны 10-р сарын 15-гэхэд хөрс хуулалтын ажлыг бүрэн дуусгаж 2020-2021 оны халаалтын циклд Хэнтий аймгийн хэрэглэгчдийг нүүрсээр ханган ажиллаж байна.

Шатах тослох материал

Компаний Чандганы хэсэг нь 2020 оны эхний үлдэгдэл 4210 литр дизелийн түлш байсан үүн дээр Багануур НИК-с 106,870 литр дизель түлшийг 153,7 сая төгрөгөөр худалдан авсан бөгөөд тухайн жилд 108210 литр дизель түлш зарцуулсан байна. Дунджаар 1-литр дизелийн түлшийг 1438 төгрөгөөр худалдан авсан байна.

Дизель түлшний зарцуулалт /литр/:

№	Техникүүд	Дизель түлшний зарцуулалт /литр/			Нийт дүн
		Нүүрс борлуулалтанд	Хөрс хуулалт	Нүүрс борлуулалтанд	
1	Экскеватор 500		21,330.0	7,670.0	29,000.0
2	Экскеватор 300	9,665.0	9,220.0	7,827.0	26,712.0
3	Шүдтэй ковш	5,450.0	1,340.0	1,630.0	8,420.0
4	Бусад тээвэр		2,620.0		2,620.0
5	Шүдгүй ковш	6,920.0	5,430.0	2,535.0	14,885.0
6	Бульдозер жижиг	420.0			420.0
7	Бульдозер том		4,050.0	1,070.0	5,120.0
8	Старикс	425.0	965.0	430.0	1,820.0
9	Запрушка	40.0	150.0	80.0	270.0
10	Пусо	290.0	400.0		690.0
11	Усны цистерн	140.0			140.0
12	Самосвалл /61-12УБЛ/	340.0	2,400.0	3,910.0	6,650.0
13	Самосвалл /79-01УНО/	330.0	2,620.0	4,290.0	7,240.0
14	Хово /90-86УБГ/		860.0		860.0
15	Хово /67-85ГУА/		830.0		830.0
16	Самосвал /76-69УНЧ /		1,230.0		1,230.0
17	Самосвал /36-77ТӨВ /		1,303.0		1,303.0
Нийт дүн		24,020.0	54,748.0	29,442.0	108,210.0
Хувиар		22.20%	50.59%	27.21%	100.00%

Нийт жилийн дизель түлшний зарцуулалтын 50,59% нь хөрс хуулалтын үед зарцуулагдаж байна.

Техник тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ

Тус уурхай нь дараах техникүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- KOMATSU-D155A, KOMATSU -D65A /Бульдозерууд/
- DOOSAN эксковатор, /300.500/
- ZL50C-автоачигч 2 ширхэг
- Старикс-1 ширхэг

- Запрушка-1 ширхэг
- Усны машин-1 ширхэг
- Автосамасвол-2 ширхэг
- Fuso-ачааны машин

Зэрэг техникүүдээр 2020 онд уурхайн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Автоачигч, бульдозер, эксковатор зэрэг техникүүдийн ашиглалтын хугацаа дууссан, явах эд анги болон бусад эд анги муудсан зэргээс шалтгаалан техник эвдэрч байсан бөгөөд дараах засвар үйлчилгээг хийсэн

Техник тус бүр дээр дараах зардлууд гарсан байна.

Үүнд:

- Бульдозеруудад 14,2 сая төгрөг
- Эксковаторын 300 мотор ээлж, болон бусад 18,6 сая төгрөг
- Эксковаторын 500 7,4 сая төгрөг
- ZL50C-автоачигчууд 17,4
- Автосамовалуудад 7,8 сая төгрөг
- Бусад техникүүд 4,3 сая төгрөг
- Мөн бусад засвар үйлчилгээнд 5,4 сая төгрөг

Сэлбэг засвар үйлчилгээний зардалд нийт 75,1 сая төгрөг зарцуулсан.

Уурхайн дэд бүтэц, тохижилт, туслах аж ахуйн хүрээнд

- Гүний худаг гаргасан
- Ажилчдын байрны дээврийг засварлаж будсан
- Тахианы байрны засварын ажлыг хийж гүйцэтгэж байгаа
- Засварын багаж, тоног төхөөрөмж хийх, хадгалах байрны засварын ажлыг
- Ажилчдын хоол хүнсэнд төмс, манжин, лууван, сонгино тарьсан
- Чацарганы суулгац 1000 ширхэгийг, мөн царгас 350 кг-г тарьсан
- Уурхайгаа тойруулж зогоон татсан /Уурхайн карераас модны хашаа хүртэл/
- 50 тоннын усалгааны ёмкусть авч чацарганы модны усалгаа болон бусад ногоо услах, услалтын систем бий болгосон.

Чандганы уурхайн ажилчдыг хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцсаар хангаж, хор саармагжуулах сүү, аарц, чацарганы шүүсийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэж байна.

“Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгаа”-г байгууллагын онцлогт тохируулан боловсруулж мөрдөн, ажилчдад ХХАА-ны дүрэм журмыг тогтмол өгч, гарын үсгээр баталгаажуулан ажилладаг.

Хүний нөөц, боловсон хүчин

2020 оны тус компани нь Захиргааны хэсэгт-10 ажилчин, Чандганы нүүрсний уурхайн хэсэгт-14 ажилчин, Харуулын албаны хэсэгт-13 ажилчин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр, нийт 37 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс эмэгтэй-12, эрэгтэй-25 ажилчидтай.

МШӨ-ний групптэй-2, энгийн групптэй-1, ахмад настан-5 эдгээр ажиллагсдыг эрүүл мэндэд харшлахгүй хөнгөн ажлаар ханган ажиллаж байна.

Тус онд ажилчдаасаа мэргэжлийн гагнуурчин, компанийн засаглал зэрэг сургалтанд хамруулсан.

Тус компани нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаанд мөрдлөг болгож, 2 жил тутам шинэчилдэг. Ажил олгогчийн зүгээс ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулж, шинээр орсон ажилтантай 3 сар хүртэл туршилтын гэрээ байгуулан ажиллуулдаг. Мөн ажиллагсдын цалинг сар бүрийн сүүлийн 7 хоногт олгож, нийгмийн даатгалын дэвтэрт үнэн зөв бичилт хийн баталгаажуулж ирлээ.

2020 оны онцлох үйл явдлууд:

- Чандганы уурхайн хэсэгт техник шинэчлэлт хийсэн
- Чандганы хэсэгт анх удаа хүнсний ногоо тариалж өөрсдийн хэрэгцээг хангасан
- Малын тэжээлд царгас, ажилчдын амжиргаанд чацарганы мод тариж нутагшуулж байгаа
- 100 тоннын авто пүү суурилуулах ажлыг эхлүүлсэн
- Чандганы хэсгийн ажилчдын байр, гал тогооны зөөврийн усны асуудлыг бүрэн шийдсэн
- Далд уурхайн музей, сургалт судалгааны төв байгуулахтай холбоотой зарим хөрөнгийг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, орон нутгийн мэдэлд актаар хүлээлгэн өгсөн.

Нийгмийн хариуцлагын хүрээнд

“Бэрх Уул” ХК-ийн Чандганы уурхай нь Мөрөн суманд байрладаг бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд Мөрөн сумын ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэх, үүссэн хогийг булах ажлыг 2020 оны 06 дугаар сарынн 22-оос 25-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн талаар танилцууллаа.

2. Гүйцэтгэх захирал А.Даваажав 2021 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө болон орлого зардлын төлөвлөгөөг танилцуулав.

" БЭРХ УУЛ " ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2021 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төрөл	Хэмжих нэгж	2019 он	2020 он	2021 он
			Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсөв
	Бүтээгдэхүүн олборлолт, борлуулалт				
1	Нүүрс	тн	58,157	56,805.8	55,000
2	Жонш	тн			
	Борлуулалтын орлого - нийт		1,363,869	1,379,543	1,538,436
1	Нүүрс	мян.төг	1,355,177	1,370,068	1,529,272
2	Жонш	мян.төг			
3	Тээврийн орлого / Нүүрс /	мян.төг	4,837	5,111	4,800
4	Бусад / Түрээс /	мян.төг	3,855	4,364	4,364
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг-нийт	мян.төг	1,494,875	1,476,223	1,540,331
1	Чандган	мян.төг	889,819	816,678	867,563
2	Захиргаа	мян.төг	489,425	505,110	514,939
3	Харуул	мян.төг	112,064	129,859	130,600
4	Дэлгэрхаан	мян.төг	2,824	22,139	21,729
5	ТУЗ-ийн зардал	мян.төг	743	2,437	5,500
	Ашиг алдагдал -нийт	мян.төг	(3,047,865)	(4,087,958)	(3,151,895)
1	Чандган	мян.төг	470,195	558,501	666,509
2	Захиргаа	мян.төг	(485,570)	(500,746)	(510,575)
3	Харуул	мян.төг	(112,064)	(129,859)	(130,600)
4	Дэлгэрхаан	мян.төг	(2,824)	(22,139)	(21,729)
5	ТУЗ	мян.төг	(743)	(2,437)	(5,500)
6	Зээлийн хүүгийн зардал	мян.төг	(1,948,463)	(1,907,189)	(1,900,000)
7	Валютын ханшын зөрүү ашиг	мян.төг	(968,396)	(1,238,706.0)	(1,250,000)

	/алдагдал/				
8	Алданга торгууль	мян.төг		(845,383)	

ТУЗ-н 2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2019 он	2020 он	2021 он
			Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсөв
1	ТУЗ-н даргын цалин	мян.төг			
2	ТУЗ-н гишүүдийн цалин	мян.төг			
3	ТУЗ-н нарийн бичгийн цалин	мян.төг			
4	Хурлын материал орчуулгын зардал	мян.төг			
5	ТУЗ-н бичиг хэргийн зардал	мян.төг			200
6	ТУЗ-н даргын томилолтын зардал	мян.төг			
7	ТУЗ-н хурлын зардал	мян.төг	180	230	300
8	ТУЗ-н НДШимтгэл	мян.төг			
9	Удирдлагын бусад /Утас, сэлбэг, бусад/	мян.төг	563	2,207	5,000
Нийт зардлын дүн		мян.төг	743	2,437	5,500

ДЭЛГЭРХААНЫ ХЭСГИЙН 2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2019 он	2020 он	2021 он
			Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсөв
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг			
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг			
3	Албан томилолтын зардал	мян.төг			
4	Хүнсний зардал	мян.төг			
5	ХХААжиллагааны зардал	мян.төг			
6	Шатах тослох материал	мян.төг			
7	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг			
8	Сэлбэг материал	мян.төг			
9	Урсгал засвар	мян.төг			
10	Цахилгаан	мян.төг	660		
11	Ус	мян.төг			
12	Дулаан	мян.төг			
13	Лицензийн төлбөр / 166А /	мян.төг	1,247	1,247	1,247
14	Лицензтэй холбоотой бусад төлбөр	мян.төг			
15	АМНАТөлбөр	мян.төг			
16	Газрын төлбөр	мян.төг	917	478	482
17	Геологи хайгуул судалгааны ажлын зардал	мян.төг		20,414	20,000
18	Байгаль орчны нөхөн сэргээлтийн зардал	мян.төг			
19	Харуул хамгаалалтын зардал	мян.төг			
20	ТЭЗҮ	мян.төг			
21	Бусад	мян.төг			

22	Зар сурталчилгаа	мян.төг			
Нийт зардлын дүн		мян.төг	2,824	22,139	21,729

ХАРУУЛЫН ХЭСГИЙН 2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2019 он	2020 он	2021 он
			Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсөв
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг	98,299	113,645	105,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	13,565	15,815	25,200
3	Албан томилолтын зардал	мян.төг			
4	Хүнсний зардал	мян.төг			
5	ХХААжиллагааны зардал	мян.төг			
6	Шатахуун тос	мян.төг	200	400	400
7	Сэлбэг материал	мян.төг			
8	Урсгал засвар	мян.төг			
9	Цахилгаан	мян.төг			
10	Ус	мян.төг			
11	Дулаан	мян.төг			
12	Бусад	мян.төг			
Нийт зардлын дүн		мян.төг	112,064	129,860	130,600

ЧАНДГАНЫ ХЭСГИЙН 2021 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Төрөл	Хэмжих нэгж	2019 он	2020 он	2021 төсөв
			Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсөв
1	Бүтээгдэхүүн олборлолт				
1	Нүүрс	тн	58,157.09	56,805.8	55,000
2	Борлуулалтын орлого - нийт	мян.төг	1,360,014	1,375,179	1,534,072
1	Нүүрс	мян.төг	1,355,177	1,370,068	1,529,272
2	Нүүрс тээврийн орлого	мян.төг	4,837	5,111	4,800
3	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - нийт	мян.төг	889,819	816,678	867,563
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг	156,712	251,759	255,000
2	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	21,767	35,654	61,200
3	Албан томилолтын зардал	мян.төг	85		
4	Хүнсний зардал	мян.төг	26,823	36,487	34,000
5	ХХААжиллагааны зардал	мян.төг	5,898	4,612	6,000
6	Шатахуун тосны зардал	мян.төг	265,447	185,810	220,000
7	Техникийн түрээсийн зардал	мян.төг	208,309	28,680	30,000
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	9,868	26,090	25,000
9	Сэлбэг материал	мян.төг	87,125	75,184	70,000
10	Байрны урсгал засвар	мян.төг	5,823	4,242	6,000
11	Цахилгаан	мян.төг	8,122	12,451	10,000
12	Лицензийн төлбөр /4590 А /	мян.төг	318	320	320
13	АМНАТөлбөр	мян.төг	33,879	34,251	38,232
14	Зээлийн хүүгийн зардал			62,653	45,000
15	Газрын төлбөр	мян.төг	2,329	2,099	2,100
16	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	мян.төг	29,078	28,402	27,500

17	Геологи,судалгааны ажлын зардал	мян.төг	20,000	6,707	20,000
18	Нөхөн сэргээлийн зардал				
19	Тээврийн зардал		153	4,014	
20	Бичиг хэргийн зардал	мян.төг	130	512	350
21	Шуудан холбооны зардал	мян.төг	151	262	300
22	Хангамжийн материалын зардал	мян.төг	718	3,056	2,000
23	Хог хаягдлын төлбөр	мян.төг	1,561	1,582	1,561
24	Ногоо, тэжээл тарих	мян.төг		7,250	8,000
25	Бусад зардал	мян.төг	5,523	4,601	5,000

№	Ашиг алдагдал -нийт	хэмжих нэгж	2019 он	2020 он	2021 төсөв
			Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Төсөв
1	Борлуулалт	мян.төг	1,360,014	1,375,179	1,534,072
2	ББӨ	мян.төг	889,819	816,678	867,563
3	Нийт ашиг	мян.төг	470,195	558,501	666,509

3. Компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг сунгаж

1. Ердийн гишүүнд:

- Раднаагийн Бадрах
- Амарсайханы Даваажав
- Бадрахын Наранзаяа
- Бат-Очирын Аригуун
- Батжаргалын Баярцэнгэл
- Өлзийбүрэнгийн Алдарбаяр нарыг

Хараат бус гишүүнд:

- Ёндонгийн Амарбат
- Дансрангийн Энхболд
- Лувсанчүлтэмийн Тэмүүжин нарыг хэлэлцүүлэн шийдвэрлэв.

4. Компани 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар алдагдал /3,830,928,751.09/ төгрөг гарсан тул хувь нийлүүлэгчдэд 2020 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ-ийн шийдвэрлэснийг танилцуулж зөвшилцөв.

5. Компанийн хэлбэрийг өөрчилж Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохтой холбоотой төслийг танилцуулж хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх бүрэн эрхийг компанийн ТУЗ-д олгож байна. Хэлбэрийг өөрчилж ХХК болохтой холбоотой Мэргэжлийн байгууллагад гаргаж өгөх албан бичиг, хүсэлт, шийдвэрийг гаргах бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн зүгээс ТУЗ-ын хуралд олгож байна.

6. Компанийн эзэмшлийн 166А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, 57.4 га талбай бүхий Дэлгэрхааны хайлуур жоншны талбайг хөрөнгө оруулагч талын хүсэлтээр “Ваёо Флюорит” ХХК-д худалдаж шилжүүлэх талаар ТУЗ-с гарсан шийдвэрийг хэлэлцүүлж зөвшилцөв.
7. Компанийн тэнцэлд бүртгэлтэй дараах хөрөнгийг “Ваёо Флюорит” ХХК-д худалдах шилжүүлэхээр ТУЗ-ийн шийдвэрлэсэнийг хэлэлцүүлэв. Үүнд:
 - а. Э-1814000100 тоот газрын гэрчилгээтэй 5331 /м.кв/ газар бүхий Ү-1814000616 гэрчилгээтэй 1768 м.кв талбайтай албан конторын барилгын талбайн 70% болох 1237 м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг, 3731.7 м.кв талбай бүхий газрын хамт
 - б. Э-1814000101 тоот газрын гэрчилгээтэй 7933 м.кв газар Ү-1814000315 тоот үл хөдлөхийн гэрчилгээтэй 792 м.кв талбай бүхий төв агуулахын барилгыг газрын хамт,
 - с. Э-1814000092 тоот газрын гэрчилгээтэй 12030 м.кв газрын 8421 м.кв талбайг, Ү-1814000314 тоот үл хөдлөхийн гэрчилгээтэй 1420 м.кв сувиллын барилгын хамт тус тус шилжүүлэхээр шийдвэрлэлээ.
8. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээтэй холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулж хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.
9. Компанийн эзэмшилд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагч талд худалдах, шилжүүлэхтэй холбоотойгоор их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгосон тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлж шийдвэрлэв.


Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Л.Тэмүүжин хэлэлцсэн асуудал тус бүрээр санал хураалтын дүнг танилцуулав.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн талаарх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. 2021 оны ажлын төлөвлөгөө, зардлын төсвийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
3. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
4. Компанийн шинэ ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдээс Р.Бадрах 16.7%, Б.Наранзаяа 16.7%, А.Даваажав 16.7%, Б.Аригуун 16.7%, Б.Баярцэнгэл 16.7%, Ө.Алдарбаяр 16.7%, тус тус саналтайгаар ердийн гишүүнээр сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд Л.Тэмүүжин 33.3%, Ё.Амарбат 33.3%, Д.Энхболд 33.3% саналтайгаар тус тус хараат бус гишүүдээр сонгогдлоо.

5. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай ТУЗ-ын бэлтгэсэн төслийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
6. Хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний талаар гаргасан ТУЗ-ын шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
7. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
8. Хөрөнгө шилжүүлэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
9. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна

Хурал:10:00 өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хянасан хурлын дарга:  /А.Даваажав/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  /Н.Содончимэг/

2021 оны 04 сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот